



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/216

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газраас “Хяналтын камерын нэгдсэн төв” байгуулж, цагдаагийн газрыг ашиглагч байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, шийдвэр гаргаж хамтран ажиллана уу гэх хүсэлтийн дагуу уг ажлын үйл ажиллагаа, цагдаагийн нэгдсэн төсөвт хяналт, шинжилгээ хийж санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Р.Машбат- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүдэд: Д.Сумаадагва- (Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга)

Г.Амирдаа- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн зарлагын бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн)

Б.Гал-Эрдэнэ- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Харилцаа, холбооны хяналтын улсын байцаагч)

М.Даваадулам- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Ганзориг- (Аймгийн цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа)

2. “Хяналтын камерийн нэгдсэн төв” үйл ажиллагаа, цагдаагийн нэгдсэн төсөвт хяналт, шинжилгээ хийж санал боловсруулах ажлыг зохион байгуулж аймгийн Засаг дарга (П.Лхагважав)-д танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Машбат)-д даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6712010988

Захирамж 2024